

МОНГОЛ БИЧГИЙН ХЭЛНИЙ САНСКРИТ ҮГИЙН БИЧЛЭГ ДЭХ “к” ҮСГИЙН ТУХАЙ*

Г.Ганчимэг**

Товч агуулга: Монгол хэлний эгшиг зохицох ёсны дагуу “к” дэвсгэр зөвхөн эм үгэнд хэрэглэгддэг зарчим эртнээс байдаг. Гэтэл монгол хэлэнд орсон санскрит гаралтай үгсийг тэмдэглэхэд энэхүү “к” дэвсгэр эр үгэнд олон тохиолдоно. Энэ бол эртний уйгур хэл, үсэг бичиг жич уйгуруудын бурхны шашны монгол хэлэнд үзүүлсэн нөлөөний илрэл юм. Санскрит хэлний *k*, *kh*, *g* хийгээд *gh* зэрэг гийгүүлэгчийг уйгур үсгийн “к” дүрсээр тэмдэглэж, үүний зэрэгцээ *h* гийгүүлэгчийг “к” дүрсээр тэмдэглэх бичлэгийн тогтолцоог уйгурууд зохиожээ. Энэ тогтолцоо нь эртний монгол бичгийн хэлэнд шууд уламжлагдаж орсон аж.

Түлхүүр үг: санскрит гаралтай үг, “к” дэвсгэр, монгол бичиг, уйгур бичгийн хэл

Харь хэлний үгс монгол хэлэнд цөөнгүй байдаг. Үүнд санскрит гаралтай үгс нь нэлээд их хувийг эзлэхээр барахгүй бараг цөм бурхны шашнаар дамжин орж ирснээрээ онцлогтой. Эрдэмтэд уг сэдвийн талаар нэлээд эртнээс судлаад, үгсийн сан, үгийн гарал, авиа зүй, шашин сурвалж судлал, соёлын нөлөөлөл зэрэг олон талаас өгүүлэл бүтээл туурвисаар иржээ (Сүхбаатар, 2014; Хүрэлбаатар, 1979; Төмөртоогоо, 1969, 1970; Mören, 1992; Shōgaito, 2003). Сурвалж бичгүүд, баримт материалд тулгуурлан үзвэл, монгол хэлэнд орсон санскрит үгсийг XVI зууны сүүл үеэр зааглан хоёр үе шатанд хувааж болно. Өмнөх үе нь XIV зуунаар голлох ба санскрит гаралтай үгс нь голдуу уйгур, согд зэрэг хэлээр дамжин орж иржээ. Харин сүүл үе буюу XVI зууны сүүл үеэс хойш төвөдийн шарын шашин монгол орноо дэлгэрснээр, үй олон төвөдийн бурхны

* Тус өгүүлийг БНХАУ-ын Нийгмийн Шинжлэх Ухааны Фондын “Юань улсын үеийн монголын бурхны шашны судар, тэдгээрийн эртний уйгур судрын харьцуулсан судлал” (18CMZ009) төслийн хүрээнд бичив.

** Монгол Улс. БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн докторант. ganchimeg_net@yahoo.com.

шашны судар ном монгол хэлэнд орчуулагдсаныг дагалдан төвөд хэлнээс санскрит үгсийг дам зээлэх болсон билээ. Үүнд хоёр зүйлийг тодруулан авч үзэх хэрэгтэй. Нэг нь зарим эрдэмтэд уг хуваарилалтын өмнөх үеийг нэн урагш түлхсэн боловч энэ нь баримт хомс, таамаглал төдий юм. Нөгөө нь XIV зууны монгол сурвалж дахь санскрит гаралтай үгсийн бичлэг нь сүүлийн үеийн сурвалжид ч уламжлагдан хэрэглэгдсэнээр барахгүй, заримыг нь эдүгээ ч хэрэглэсээр байна.

Дунд эртний буюу XIV зууны монгол хэлээрх бурхны шашны сурвалжуудыг шүүж үзвэл, санскрит гаралтай үгсийн их зонхи нь уйгур хэлээр дамжин ирсэн байх бөгөөд зарим нь согд (sogdian), тохар (tocharian), хотан (khotan saka) зэрэг хэлнээс дам оржээ. Тиймийн учир, тухайн үеийн санскрит гаралтай үгс нь бичлэгийн хувьд уйгур хэлэн дэх санскрит гаралтай үгстэй дийлэнх нь адил юм. Гэвч зарим нь монгол хэлний бичлэгийн онцлогийг харгалзан бага зэргийн ялгаатайгаар бичигдэх болжээ.

Уйгурууд IX зууны сүүл үеэс бурхны шашныг шүтэн, бурхны шашны судар номуудыг орчуулж эхэлсэн түүхтэй. Монголчууд хөгжин мандсан XIII зуун болоход, уйгуруудын бурхны шашин ихэд хөгжиж, голдуу бурхны шашнаар уйгур хэлэнд нэвтрэн орсон санскрит гаралтай үгс нь ч тогтворжсон хэмээн үзэж болно. Улс төр, хэл соёл, үсэг бичиг зэрэг талын нарийн нягт харьцаа нь олон зууны турш монголчууд хийгээд уйгуруудын хооронд тогтсон тул, монголчуудын бурхны шашинд итгэх итгэл үнэмшил нь нэмэгдэж, улмаар дэлгэрэн хөгжихөд уйгурын бурхны шашин тун чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээн эрдэмтэд дурдсан байдаг. Уйгур хэлээр дамжин монгол хэлэнд орсон санскрит үгс нь энэхүү нөлөөний чухал илрэлийн нэг болох юм.

Эртний уйгур хэлнээс монгол хэлэнд дам орсон санскрит үгсийн ихэнх нь уйгур бичлэгийн онцлогийг хадгалсан байдаг хэмээн дээр дурдсан. Үүний нэг жишээ нь тус өгүүлэлд авч үзэх санскрит гаралтай үгсийг тэмдэглэхэд ашигласан “k” дэвсгэр болно. Олны мэдээжээр монгол хэлийг багтаасан алтай язгуурын хэлнүүдийн нийтлэг онцлог бол “эгшиг зохицох ёс” билээ. Уг дүрмийн хүрээнд уйгуржин монгол бичгийн “H” (үгийн дунд “ee”, үгийн эцэст “(”) дүрс нь зөвхөн эр үгийн $q(y)$ гийгүүлэгчийг тэмдэглэж, “k” (үгийн дунд “k”, үгийн эцэст “it”) дүрс нь эм үгийн $k(g)$ гийгүүлэгчийг тэмдэглэх дүрэм тогтолцоотой. Гэтэл санскрит зээллэг үгсийг тэмдэглэхэд энэхүү бичлэгийн дүрэм эвдэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл зарим санскрит гаралтай үгсийг тэмдэглэхэд эгшиг зохицох ёсоо дагасан бичлэгийн дүрэм зохих хэмжээгээр хувирсан байна. Энэ нь уг ёсондоо уйгуруудын санскрит гаралтай үгсийг тэмдэглэх бичлэгийн тогтолцоог шууд шилжүүлэн авч ашигласан хэрэг юм.

Монгол хэлэн дэх санскрит гаралтай үгсийн талаарх судалгаа нэлээд эртнээс өрнөж, цөөнгүй бүтээл нийтлэгдсэн боловч зонхилох нь зөвхөн авиа зүйн үүднээс авч үзсэн байх ба эртний уйгур хэлтэй холбон, бичлэгийн онцлогийг харгалзаж судалсан нь маш ховор. Чухам энэхүү тусгай сэдвийг судалсан бүтээл хараахан үгүй байсаар гэж хэлж болмоор. Тиймийн учир, доор дундад эртний монголын бурхны шашны сурвалжуудад суурилан, санскрит гаралтай үгийг тэмдэглэхэд ашигласан “k ” дүрс, жич үүнтэй холбогдох авиа болон бичлэгийн тогтолцооны тухай өгүүлэх болно.




I





XIV зуун бол монгол бурхны шашны судар номын орчуулгын анхны үе шат билээ. Тухайн үед чамгүй олон судар ном монголчлогдсон гэж эрдэмтэд дуу нэгтэй үздэг боловч эдүгээд хүртэл үлдсэн нь маш цөөн, ихэнх нь Турфан, Дунхуан, Хар хотоос илрүүлсэн тамтаг тасархайнууд юм. Эдгээр ховор нандин сурвалж, баримт материалуудын олонх нь эрдэм шинжилгээний эргэлтэд орж судлагдсан хэдий ч судлаачдын сонорт ороогүй цөөн хэдэн сурвалж бий. Турфаны олдворын ихэнх нь Герман улсад хадгалагдаж буй бөгөөд нэлээд сайн судлагдахын сацуу, уг сурвалжийн фото зургууд нь цахим сүлжээнд (<https://turfan.bbaw.de>) нийтлэгдсэн учир хэн ч бай үнэ төлбөргүй ашиглах боломжтой (Cerenodnom; Taube, 1993). Японд хадгалж буй цөөн хэдэн Турфанаас илрүүлсэн монгол сурвалжийн тасархайг Мураяма (Murayama, 1958; 1959) судалж, фото зургийн хамт нийтлүүлсэн билээ. Мөн Дунхуаны олдвор дахь монгол сурвалжийн тамтаг тасархайнуудыг ч эрдэмтэд эрчимтэй судалсан (Garudi, 2004a, 2004b; Otgon, 2010; Olivér, 2014) буй. Эдгээрээс гадна, Францын Улсын номын санд хадгалагдаж буй Пеллио (P. Pelliot)-ийн цуглуулга дахь Дунхуанаас илрүүлсэн *Pelliot ouïgour grotte 181* анги доторх монгол сурвалж хараахан судлагдаагүй байсаар. Үүнийг бид шинээр ашиглах болно. Орост хадгалагдаж буй Хар хотоос илрүүлсэн монгол сурвалжийг Унгарын эрдэмтэн Хар Дорж (Kara, 2007) нарийн судалжээ. Түүнчлэн БНХАУ-д хадгалж буй Хар хотын олдворыг Ёшида Жүничи (Yosida Jun'ichi) болон Ж.Чимэддорж нар (Yoshida, Chimeddorj 2008: 12-182) хэвлүүлсэн билээ.

Дээрх XIV зууны үеийн сурвалж бичиг баримт материалуудаас гадна, “Дотоод ба гадаад тарни ном” гэж нэрлэж болохуйц 1431 онд барласан хятад, санскрит, төвөд хийгээд монгол дөрвөн хэл хавсарсан судар тарнийн цуглуулга мөн бидний ашиглах материалын гол бүрэлдэхүүнд багтаж байна. Энэхүү сурвалж нь БНХАУ-ын Улсын номын сан хийгээд Франц улсын Гиме Музей (Musée Guimet)-д нийт гурван хувь хадгалагдаж буй бөгөөд В.Хайссиг (Heissig 1976), Оюунбилиг (Oyunbilig, 2013) нар судлан, өгүүлэл нийтлүүлжээ. Уг эхийн фото зургийг Шюн Вэнь Бинь, Жэн Дүй,

Ли Бао Вэнь, Эрхэмт нар хэвлүүлсэн байна (Xiong wen bin; Zeng dui, 2011; Li Baowen; Erkimtū, 2015). Уг сурвалжид оршил болон төгсгөлөөс гадна, 20-оод судар номыг багтааснаас, үүнд оршил, төгсгөл, “Бурхад бодисадва нарын хөрөг, нэрс, тарни”, “Хорин нэгэн дарь эхийн магтаал” зэрэг таван хэсгийн агуулгыг дөрвөн хэлээр хавсаргажээ. Хэдийгээр XV зууны эхэн хагаст хэвлэгдсэн боловч уг сурвалж нь Юань улсын үеийн монгол хэл, жич уйгуржин монгол бичгийн бичлэгийн онцлогийг ихэд хадгалсны зэрэгцээ, бурхны шашны нэр томъёоны бичлэгийн хувьд төвөдийн шарын шашны нөлөө хараахан ороогүй тул, XIV зууны онцлогийг залгамжилсан хэмээн үзэж болох юм.

Дээрх уйгуржин монгол бичгээрх бурхны шашны сурвалжийг шүүж үзсэний дүнд, “к” дэвсгэрийг агуулсан санскрит гаралтай үгс нийт 34-ийг хүснэгтэд түүж жагсаав.

	Бичлэгийн зураг	үсгийн галиг	үгийн галиг	санскрит галиг
1		"k'm	agam	āgama
2		"k'swby	akšobi	akṣobhya
3		"mwk'sydy	amogasidi	amoghasiddhi
4		"s'kky	asangki	asaṃkhyeya
5		b'd'k	badag	pādaka
6		byr'dyk'pww'	biratikabut	pratyekabuddha
7		č'kr-	čakr-a	cakra
8		t'kynys	dakinis	ḍākinī
9		tyb'kk'r	dibanggar	dīpaṃkāra
10		k'nd'ryys	gandarvis	gandharva
				
11		k'rwdy	garuḍi	garuḍa
12		k'dyrkww'	grdirkut	gr̥dhrakūṭa
		k'dyrkww'		
13		kyryw-	giriū-a	grīva
14		k'b'l'	gabala	kapāla
15		k'l's-a	kalas-a	kailāsa
16		k'lb'y'r'ks	kalbavarakṣ	kalpavṛkṣa

17		<i>k'ly</i>	<i>kali</i>	<i>kālī</i>
18		<i>klb</i>	<i>g(a)l(a)b</i>	<i>kalpa</i>
		<i>k'l'b</i>	<i>galab</i>	
		<i>k'lb</i>	<i>g(a)lab</i>	
19		<i>k'rm-</i>	<i>karm-a</i>	<i>karma</i>
20		<i>kyn'ry</i>	<i>kinari</i>	<i>kin̄nara</i>
		<i>ky''rys-</i>	<i>kinaris-a</i>	
21		<i>ks''</i>	<i>kšan</i>	<i>kṣaṇa</i>
22		<i>mww'k'ly'n'</i>	<i>modgalayana</i>	<i>maudgalyāyana</i>
23		<i>r//k'r'q</i>	<i>r[a]a]garaq</i>	<i>rājagrha</i>
		<i>r'č'k'"" (?)</i>	<i>ra]agrq?</i>	
24		<i>s''kk'y-</i>	<i>sanggay-a</i>	<i>saṅghāya</i>
25		<i>swk'y'dy</i>	<i>sukavati</i>	<i>sukhāvātī</i>
26		<i>syk'mw'y</i>	<i>sikamuni</i>	<i>śākyamune</i>
27		<i>šyr'y'k</i>	<i>širavak</i>	<i>śrāvaka</i>
28		<i>shwk</i>	<i>šlok</i>	<i>śloka</i>
		<i>šhwk</i>		
29		<i>y'ks's</i>	<i>yakšas</i>	<i>yakṣa</i>
30		<i>y'm'd'k''</i>	<i>yam(a)ntaka</i>	<i>yamāntaka</i>
31		<i>ywk'dy</i>	<i>yukti</i>	<i>yukti</i>
32		<i>yyru-b'ky</i>	<i>viru-baki</i>	<i>virūpākṣa</i>
33		<i>yyrud'ky</i>	<i>virudaki</i>	<i>virūḍhaka</i>
34		<i>yyy''kyryw'</i>	<i>viyankirit</i>	<i>vyākārit</i>

Хүснэгт дэх зарим зүйлд товч тайлбарлах шаардлагатай: [] хаалтад тасарч дутсаныг, () хаалтад гээгдсэн дэвсгэрүүдийг тус бүр нөхөн сэргээж, эргэлзээтэй галигийн дараа асуултын тэмдэг хадав. 8, 10, 29-д байх *dakinis*, *gandarvis*, *yakšas*-ын үгийн эцсийн *s* гийгүүлэгч нь уугал санскрит дэвсгэр бус, монгол хэлний олон тооны дагавар юм. 20-д байгаа үгийн хоёр дахь

бичлэг *kinaris-a*-ийн *s* нь мөн олон тооны дагавар бөгөөд *a* нь монгол хэлний өгөх оршихын тийн ялгалын нөхцөл болно.

“Уйгуржин” хэмээдэг монгол үсэг бичиг нь согдоос гаралтай уйгур бичгийг үлгэрлэн монгол хэлийг тэмдэглэх болсон гэх үзлийг зонхилох эрдэмтэд санал нэгтэй дэмждэг. Согд, уйгур бичигтэй адилаар монгол бичиг ч үсэг тэмдгийн хангалтгүй байдлаас үүдэн, нэг тэмдэг дүрсээр олон авиаг илэрхийлэх тохиолдол нэлээд оршино. Энэхүү онцлог нь монгол хэлний уугуул үгсийг тэмдэглэхэд асуудал цөөн үүсгэх боловч харь гаралтай үгсийг тэмдэглэхэд эргэлзээ мадаг үүсгэнэ. Дээрх жишээ үгсийг багтаасан санскрит гаралтай үгсийг тэмдэглэхэд уг асуудал нэн тод мэдэгдэнэ. Тиймээс санскрит гаралтай үгсийг эрдэмтэд янз бүрээр галиглан уншдаг. Хэдий тийм ч бидний ойлголтоор монголын бурхны шашны судар номын орчуулгын анхны үе шат болох XIV зуунд санскрит хэлний шашны нэр томьёо нь бараг бүгд эртний уйгур хэлээр зууч болгон монгол бичгийн хэлэнд оржээ. Өөрөөр хэлбэл, зууч хэл болох уйгур хэлнийхээ бичлэгийн онцлог, дуудлагыг нь ч шууд хүлээн авсан хэрэг юм. Үүнд дуудлага нь уугуул санскрит хэлний дуудлагыг нэлээд хадгалж үлдсэн байх учиртай. Тиймээс бид санскрит дуудлагыг мөрдөн, магадгүй бусад эрдэмтдээс бага зэрэг өөрөөр галигласан юм. Жишээлбэл санскрит хэлний *grdhrakūṭa*-г харгалзан “*kidireKoa*”-г *grdirkut* гэсэн бөгөөд уг галиг мөн ч эргэлзээтэй юм. Тус үгийг нэлээд олон судар сурвалжид “*kedireKoa*” гэж, эрдэмтэд *gendiregūd* гэж галигласан байдаг. Үнэндээ тус үгийн тухайн үеийн зөв бичлэг нь “*krdireKoa*” (дундад эртний монгол бичигт үгийн дундах *r* гийгүүлэгч нь хоёр шүд “*-ee*”-тэй ихэд төстэй бичдэг, хүснэгт дэх 20 дугаар жишээ *kinari*-гийн *r* үсгээс лавлана уу), галиглавал **grdirakut* бөгөөд, уугуул санскрит үгийн дуудлага бичлэгтэй маш ойролцоо тусгасан ажээ. Энэхүү бичлэг нь аажимдаа “*kedireKoa*” болж, бичлэгээ даган монголчууд *gendiregūd* гэдэг болсон учиртай. Үүнтэй адилаар бичлэгийн хэлбэлзлийг даган дуудлага өөрчлөгдсөн жишээ цөөнгүй бий. Үүний сацуу дуудлагаа даган, бичлэг нь хувирсан үзэгдэл ч мөн бий. Жишээлбэл, санскрит хэлний *śāsana* гэх үг эртний уйгур хэлэнд *šazin* болж, энэ нь монгол хэлэнд аман яриагаар уламжлан явсаар “*Sejia* (*Zejia*, шажин)” гэх бичлэг үүсгэсэн аж (Ganchimeg, 2024). Эдгээр асуудал нь хэдийгээр тус өгүүлэлд холбогдох боловч нэн өргөн хэмжээнд авч үзэх шаардлагатай тул энд өгүүлэхэд бэрх.

Доор гол сэдэв болох санскрит гаралтай үгийг тэмдэглэсэн “*k*” дэвсгэрийн тухай өгүүлье. Санскрит хэлний нэр үгэнд эр, эм хийгээд саармаг гэгч гурван хүйсийн ялгалтай боловч тэр нь авиа хийгээд бичлэгт суурилсан тогтолцоо биш. Өөрөөр хэлбэл, санскрит хэлний хүйсийн ялгал нь монгол хэлний эгшиг зохицох ёсноос ангид өөр зүйл юм. Уугуул санскрит үгсийн дуудлагыг үндэслэвэл, хүснэгтэд жагсаасан бүх үгс нь монгол хэлэнд эгшиг зохицох ёсны дагуу цөм эр үг болох нь харахад


илхэн. Үүнийг зарим ярианы хэлэнд идэвхтэй хэрэглэгддэг үгсийн орчин цагийн хувирсан бичлэг давхар батална. Жишээлбэл: “bideit”-г “bide” ”(бадаг), “krodli”-г “Gerodli” (гарди), “kbi:la”-г “Gebila” (гавал), “kseea”-г “feeezea” (агшин), “Sikimol (Sekimol)”-г “Zeejemol” (Шагжамуни) хэмээн тус тус бичих болсон нь монгол хэлэнд эдгээр үгс чанга авиагаар дуудагддаг байсныг илэрхийлнэ. Эдгээр үгсийн дуудлага нь эр байсан ч бичлэгтээ “Н” дүрсийг бус, харин цөм “к” дүрсийг ашигласан нь эгшиг зохицох ёсоо дагасан монгол зөв бичлэгийн дүрмийг зөрчсөн нь маргаангүй зүйл. Үүнээс үүдэн яагаад ийнхүү бичих болсон бэ? гэх асуулт аяндаа үүснэ.

Уйгуруудын бурхны шашин нь XIII-XIV зууны үед монголчуудын бурхны шашин шүтлэгт маш их нөлөө үзүүлснийг эрдэмтэд сүүлийн үед хүлээж авдаг болсон билээ.

Энэхүү нөлөөний нэг илрэл нь эртний уйгур хэл хийгээд уйгур хэлээр дамжин дам зээлсэн санскрит зэрэг бусад харь хэлний шашны нэр томьёо болох юм. Үүнд яриангүй бидний авч үзэн буй чанга хөндийн ялгалыг харгалзалгүйгээр “к” дүрсээр тэмдэглэсэн санскрит гаралтай үгс багтана. Өөрөөр хэлбэл “к” дүрсийг чанга үгэнд хэрэглэх болсон нь санскрит хэлний нэр томьёог тэмдэглэх явцад уйгуруудын зохиосон бичлэгийн тогтолцоо байсныг монголчууд XIV зуун магадгүй түүнээс өмнө өөрийн сурвалж бичигт шууд шилжүүлэн ашигласан хэрэг.

II

Монгол хэлтэй адилаар эртний уйгур хэлэнд ч эгшиг зохицох ёс байдгаар үл барам уйгур бичигт мөнхүү “Н”, “к” хоёр өөр дэвсгэр дүрс оршиж, эгшиг зохицох ёсны дагуу “Н” нь эр үгийн $q(\gamma)$ гийгүүлэгчийг тэмдэглэж, “к” нь эм үгийн $k(g)$ гийгүүлэгчийг тэмдэглэх бичлэгийн үүрэгтэй. Гэтэл санскрит гаралтай үгсийг тэмдэглэхэд “к” дүрс нь эр үгэнд системтэй хэрэглэгдэнэ. Энэ нь өмнө эшилсэн жишээнд харуулсны дагуу, монгол хэлэн дэх санскрит гаралтай үгстэй ялгаагүй онцгой үзэгдэл болохоор барахгүй, санамсаргүй тохиолдол биш юм.

	Уйгур бичлэг	галиг	санскрит галиг
1		agam	āgama
2		amogasidi	amoghasiddhi
3		asangki	asaṃkhyeya
4		padak	pādaka
5		kšan	kṣaṇa
6		sanggay-a	saṃghāya

7		<i>sukavati</i>	sukhāvātī
8		<i>ślok</i>	śloka
9		<i>yukti</i>	yukti
10		<i>viyakrit</i>	vyākārit

Хэтэрхий нуршин сунжрахаас болгоомжлон, хүснэгтэд жагсаасан монгол сурвалж дахь санскрит гаралтай үгстэй тохирох эртний уйгур хэлний санскрит гаралтай үгсээс 10-ыг сонгож хадав. Санскрит гаралтай үгсийг эртний уйгур сурвалжид олон янзаар бичдэг боловч бидний авч үзэн буй “k” дүрсийг “h” дүрсээр бичсэн жишээ одоохондоо харагдсангүй. Өөрөөр хэлбэл эртний монгол сурвалжид “k” дүрс бүхий санскрит гаралтай үгс нь эртний уйгур сурвалжид мөн адил “k” дүрсээр тэмдэглэсэн байна. Эртний уйгур хэлэн дэх санскрит үгсийн нэлээд хувь нь согд, тохар эсвэл хотан хэлээр дам зээлсэн хэмээн уйгур судлаачид үздэг. Энэ нь бурхны шашин Энэтхэг орноос хойш торгоны замыг дагаж дэлгэрсэн замналтай нийцнэ. IX зууны сүүл үед бурхны шашныг өргөнөөр хүлээн авснаас хойш, олон зууны турш бурхны судар номуудыг эртний уйгур хэлэнд орчуулах явцад санскрит үгсийг уйгурууд өөрсдөө үг хэл, үсэг бичигтээ зохицуулсан онцгой тогтолцоог бий болгожээ. “k” дүрсийг чанга үгэнд хэрэглэх нь энэхүү тогтолцооны нэгэн жишээ юм. Тухайлбал, эгшиг зохицох ёсоо дагасан бичлэгийн дүрмийг эвдэн, чанга хөндийн ялгалгүйгээр санскрит хэлний зарим гийгүүлэгчийг нийдэм “k” үрсээр тэмдэглэх болжээ. Бидний ажигласнаас харахад, “k” дүрс нь голдуу санскрит хэлний *k*, *kh*, *g* хийгээд *gh* зэрэг дөрвөн хоолойн гийгүүлэгчийг тэмдэглэнэ. Үүнд санскрит хэлний *k* хийгээд *kh* гийгүүлэгчийг тэмдэглэхэд “k” дүрс нь эртний уйгур хэлний *k* гийгүүлэгчийг илэрхийлэн, санскрит хэлний *g* хийгээд *gh* гийгүүлэгчийг тэмдэглэхэд “k” дүрс нь эртний уйгур хэлний *g* гийгүүлэгчийг илэрхийлнэ.¹

Энэ нь уйгурууд өөрийн бичлэгийн дүрмийг эвдэн санскрит хэлний гийгүүлэгч авиаг ялгаатай тэмдэглэсэн бичлэгийн өөрчлөлт юм. Санскрит хэлний *k*, *kh*, *g*, *gh* гэх дөрвөн гийгүүлэгч нь хоолойн гийгүүлэгч (*kaṇṭhya*) гэсэн нэг ангилал доор хуваагддаг. Үүнийг уйгурууд мөн багцлан авч “k” дүрсээр тэмдэглэн тогтжээ. Ийнхүү үйлдсэний гол учир нь санскрит хэлний “хий авиа” (*ūṣman*) гэгч шүргэх гийгүүлэгч *h*-аас ялгахын төлөө

¹ Үнэндээ дуудлага авианы хувьд санскрит хэлний *k* хийгээд *g* гийгүүлэгч нь нэн ойролцоо, *kh* хийгээд *gh* гийгүүлэгч нь хоорондоо илүү дөхөх юм. Энэ байдал дор эртний уйгур бичгийн “k” дүрс санскрит хэлний *k* хийгээд *g* гийгүүлэгчийг тэмдэглэхэд *g* байж, *kh* хийгээд *gh* гийгүүлэгчийг тэмдэглэхэд *k* болох нь илүү зүйтэй юм. Уйгур судлаачид санскрит хэлний дуудлагын авианд суурилсан бус, харин латин галигт тулгуурлан *k* хийгээд *kh*-г тэмдэглэсэн “k” дүрсийг *k* гийгүүлэгчээр үзэн, *g* хийгээд *gh*-г тэмдэглэсэн “k” дүрсийг *g* гийгүүлэгчээр үзсэн бололтой. Аль нь ч байсан бидний гол сэдвийг бараг нөлөөлөхгүй тул уйгур судлаачдын уншлагыг баримтлан цаашдаа өгүүлэх болно.

юм. Уг гийгүүлэгчийг эртний уйгур бичигт эр үгэнд тохиолдох “Н” дүрсээр тэмдэглэсэн байдаг.

Жишээлбэл:

	Уйгур бичлэг	галиг	санскрит галиг
1		arhant	arhat
2		gr(a)h	graha
3		maha	mahā
4		račagrha	rājagṛha

Дээрх дөрвөн жишээнээс санскрит хэлний *h* гийгүүлэгчийг эртний уйгур бичигт “Н” дүрсээр жигдлэн тэмдэглэсэн байх нь харахад илхэн. Үүнд ялангуяа хоёрдугаар *gr(a)h* хийгээд дөрөвдүгээр *račagrha*-ад “k” болон “Н” дүрс нэг үгэнд бичигдсэн нь санскрит үгийг тэмдэглэхэд энэ хоёр дүрсийн адил бус үүрэг гүйцэтгэж байхыг тодорхой харуулна. Үнэндээ “Н” дүрсийн санскрит хэлний *h* гийгүүлэгчийг тэмдэглэх нь эртний монгол сурвалжид тэр хэвээрээ хэрэглэгдсэн билээ. Дээрх дөрвөн жишээг авч үзвэл, тэдгээр нь монгол сурвалжид тус бүр “ferēēēoa” (*arqand*) хийгээд “ferēēēoa” (*arqad*), “kre(” (*gray*) хийгээд “kre(” (*garay*), “Me(T” (*maq-a*), “rejekre(” (*raḡagray*) хийгээд “rejekre(” (*raḡagaray*) зэрэг бичлэгтэй үлджээ.

“Н” дүрсээр санскрит хэлний *h* гийгүүлэгчийг эс тэмдэглэсэн жишээ бидний цуглуулсан материалд ганц илрэв. Энэ нь санскрит хэлний “сурахуйн шүтээн” гэх утга бүхий śikṣāpada гэх үгийг эртний уйгур сурвалжид  ś(a)hṣap(a)t гэж, санскрит хэлний *k* гийгүүлэгчийг “Н” дүрсээр тэмдэглэсэн байна. Энэ нь бидний саналтай эсрэгцэх баримт болох мэт харагдах боловч цаанаа учиртай юм. Тус үгийг уйгурууд согд хэлний *cxʼpɫ*-аас дам зээлсэн гэж үздэг. Уугуул санскрит хэлэнд асан *k* гийгүүлэгч нь согд хэлэнд *x* гийгүүлэгчээр зөөлрүүлэн тэмдэглэгдсэнийг уйгурууд *h*-аар үзэн “Н” дүрсээр тэмдэглэх болсон гэж үзмээр.² Энэ онцлог нь монгол сурвалжид уламжлагдан орж, “Ceeesebioa”, “CieezeBa”, “CieeseBa” гэж өөр өөрөөр бичиж байсан бөгөөд сүүлийн үед уугуул санскрит хэлэнд нэн ойртуулан “Zeezebioa” гэх болжээ.

Өмнөх хэсэгт өгүүлснээр, эртний уйгур хэлний авиа хийгээд үсэг бичгийн хязгаарлагдмал байдлаас болж, санскрит хэлний *k*, *kh*, *g* хийгээд *gh* зэрэг гийгүүлэгчийг гагц “k” дүрсээр илэрхийлэн, санскрит хэлний *h* гийгүүлэгчийг “h” дүрсээр тэмдэглэж зуршсан байна. Энэхүү тогтолцоо нь

² Согд хэлний үгийг тэмдэглэх *x* болон эртний уйгур хэлэнд дэх харь үгэнд ашиглах *h* нь авиа дуудлага ижил юм. Өөрөөр хэлвэл энэ нь ижил дуудлага бүхий авиаг хоёр өөр үсгээр тэмдэглэсэн хэрэг.

чухамдаа согдоос үүсэлтэй байж магадгүй. Учир нь уйгур бичиг нь согд бичгээс гаралтай бөгөөд, уйгурууд мөн согдуудын маанийн шашин, бурхны шашны нөлөөг ихээр хүртсэн билээ. Ямартай ч энэхүү санскрит гаралтай үгсийг тэмдэглэх тогтолцоо нь эртний монгол бичгийн хэлэнд бараг тэр хэвээрээ уламжлан оржээ. Энэ нь XIII-XIV зууны үе буюу монголын бурхны шашны түүхийн анхны үед уйгуруудын үзүүлсэн хүчтэй нөлөөний илрэл болох юм. Тухайн үед бурхны шашны шүтэн бишрэгчид байсан маш олон уйгурууд монголын хаан төрийн дээд давхаргад өндөр тушаалтай ажиллаж байснаар барахгүй, хаан, хатны зарлиг доор бурхны шашны тахил тайлга, судар номын орчуулгын ажилд маш идэвхтэй оролцож байсныг түүхэн сурвалжид тэмдэглэж үлдээсэн байдаг. XIV зууны эхэн үеэс бурхны шашны судар номыг монгол хэлэнд орчуулахад уйгурууд асар их нөлөө үзүүлснээр үл барам шууд оролцсон юм. Жишээлбэл, уйгур хүмүүн Пражняшри “Долоон өвгөн нэрт одны судар”-ыг уйгур хэлнээс монгол хэлэнд орчуулсан байна. Монгол бурхны шашны судар номын орчуулгын түүхэнд хамгийн алдар цуутай Чойжи-Одсэрийг ч сурвалж бичиг баримт материалуудад уйгур гаралтай гэж тэмдэглэсэн байдаг. Уйгур хийгээд монголын хэл, үсэг бичиг нь ойр харьцаатайгаар зогсохгүй, монгол бурхны шашны хэл хэллэг, нэр томьёонд эртний уйгур хэлний үгс ч цөөнгүй орших бөгөөд зарим нь эдүгээд хүртэл уламжлагдан иржээ. Эдгээр нь үнэхээр зарим судлаачдын дурдсан мэт “Монголын бурхны шашин нь уйгурын бурхны шашнаас үүсэж, төвөдийн бурхны шашны нөлөөн доор бойжжээ” (Matsukawa, 2004) гэх үзэлд хүргэнэ. Энэ өгүүлэлд авч үзсэн монгол хэлэн дэх санскрит үгсийг уйгураар дамжин зээлснийг нэн хялбараар хэлбэл, ойлгож орчуулахад бэрхтэй эдгээр шашны нэр томьёонуудыг уйгурууд аль эрт өөрийн үсэг бичигт тохируулан боловсруулж, тогтсон системтэй болгосныг монголчууд өөрсдийн үсэг бичигт “бэлэн хоол” болгож шууд буулган авсан нь тун амар хялбар байсан биз ээ.

Бурхны шашны дэлгэрэлтийг дагалдан, санскрит үгс нь зохих хэмжээний өөрчлөлттэйгөөр эхлээд согд, тохар, хотан зэрэг хэлэнд ороод, дараа нь эдгээр зууч хэлнүүдээс эртний уйгур хэлэнд орсон түүхэн замналтай. Өөрийн үг хэл, үсэг бичигтээ зохицуулахын тулд, санскрит гаралтай үгс дахинтаа хувирсан юм. Тийм ч учраас эртний уйгур хэлэнд орсон санскрит гаралтай үгс нь уугуул санскрит хэлтэй зарим тохиолдолд их зөрөх болжээ. Энэ байдал нь эртний монгол бичгийн хэлэнд тэр хэвээр уламжлан оржээ. Уугуул санскрит хэлнээс зайдсан хийгээд монгол бичлэгийн дүрэм онцлогоос зөрсөн үзэгдэл нь Юань улсын мөхөл хийгээд Уйгурууд бурхны шашныг тэвчин, исламын шашныг шүтэх болсон түүхэн явдлаас шалтгаалан уламжлал тасарч, олон үе улирахад хүмүүст тайлан ухаарахад бэрх болсон юм. XVI зууны сүүл буюу төвөдийн шарын шашин Монгол оронд дэлгэрэх үед, Юань улсын үеийн санскрит гаралтай үгсийн бичлэгийн учир шалтгаан баларч, монголчууд байтугай уйгурууд

ч өөрсдөө мэдэхээ больсон тул, уугал санскрит хэлэнд тулгуурлан нэлээд их хэмжээгээр шинэчилсэн ажээ. Энэ хүрээнд монгол хэлний эгшиг зохицох ёсыг дагасан бичлэгийн дүрмийг мөрдөн эр үгэнд хэрэглэж байсан “k” дүрсийг “H”, “G”-аар сольж, дээр дурдсан “bide(”, “Gerodl”, “Gebila”, “feeezea”, “Zeejeemonl” гэх зэрэг шинэ бичлэг үүсжээ. Харин “Sloit (Zloit)” гэж бичиж байсан эр үгэнд авианы хувирал үүсэж, “Siloit” (шүлэг) хэмээх эм үг болсон нь “k ” дүрсээр бичиж байсныг харуулсан нэгэн жишээ юм.

Summary

According to vowel harmony, the letter “k” of the Uyghur-Mongolian alphabet must be used only in the so-called ‘female’ words. In the Sanskrit loan words in Mongolian, however, the letter “q” was used in many ‘male’ words. It is one of the influences on the Mongolian languages by the Old Uyghur language scriptures and their Buddhism. Due to the lack of their letter, Uyghurs have created their own way to transcribe Sanskrit words: letter “q” for the Sanskrit consonants *k*, *kh*, *g* and *gh*, letter “q” in the other hand for Sanskrit consonant *h*. This writing system was taken to the Sanskrit loan words in Mongolian directly and without any changes during the Yuan-period.

Ном зүй

Cerensodnom D., Taube M. (1993). *Die Mongolica der Berliner Turfansammlung*. Berliner Turfantexte XVI. Berlin: Akademie Verlag. [Cerensodnom D., Taube M. (1993). *The Mongolica of the Berlin turfan collection*. Berliner Turfantexte XVI. Berlin: Academic press.]

Heissig, W. (1976). Zwei mutmasslich mongolische Yüan Übersetzungen und ihr Nachdruck von 1431. *Zentralasiatische Studien*, Band 10, pp. 7-39. [Heissig, W. (1976). Two presumably Mongolian Yüan translations and their reprint from 1431. *Centralasien Studies*, Volume 10, pp. 7-39.]

Matsukawa, Takashi 2004. Some Uighur Elements Surviving in the Mongolian Buddhist Sūtra of the Great Bear. *Turfan Revisited – The First Century of Research into the Arts and Cultures of the Silk Road*. Ed. Durkin-Meisterernst D., S.-Ch. Raschmann etc. Berlin: Dietrich Reimer Verlag. P. 203-207.

Murayama, S. (1958/1959). Zwei mongolische Manuskripte aus Ost-Turkestan. *Central Asiatic Journal*, Vol. IV. P. 279-288. [Murayama, S. (1958/1959). Two Mongolian manuscripts from East Turkestan. *Central Asiatic Journal*, Vol. IV. P. 279-288.]

Olivér, K. (2014). A Heart-Sutra Fragment from Dunhuang. *Quaestiones Mongolorum Disputatae*, X, P. 1-5.

Shōgaito Masahiro. (2003). Uighur influence on Indian words in Mongolian

Buddhist texts. *Indien und Zentralasien Sprach- und Kulturkontakt*. Hrsg. von S. Bretfeld und J. Wilkens. Veröffentlichungen der Societas Uralo-Altaica, Band 61. Wiesbaden: Harrassowitz Verlag. P. 119-143.

Сүхбаатар, О. (2014). *Монгол хэлэн дэх Самгарди махбод*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Sukhbaatar, O. (2014). Sanskrit elements in Mongolian. Ulaanbaatar: Soyombu printing.]

Төмөртоого, Д. (1969/1970). XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгал дахь самгарди үгсийн бичлэгийн онцлог. *Studia Linguae et Litterarum*, Tom. VII. X.209-219. [Tumurtogoo, D. (1969/1970). Spelling Characteristics of Sanskrit Vocabulary in Mongolian Literature of the 13th-14th Centuries. *Studia Linguae et Litterarum*, Tom. VII. P. 209-219.]

Хүрэлбаатар, Л. (1979). Монгол хэлэнд орсон Санскрит үг. Олон улсын монголч эрдэмтдийн III их хурал. Улаанбаатар. X. 268-273. [Khurelbaatar, L. (1979). Sanskrit words in Mongolian. Proceedings of the 3rd international congress of Mongolists. Ulaanbaatar. P. 268-273.]

Ganchimeg, G. (2024). Erten-ü uyiyur kelen-ü uyiyur kelen-ü z/ž geyilgölögči mongyol kelen-dü qoyar saluysan uçir: *Öbör mongyol-un yeke suryayuli-yin erdem sinjilegen-ü sedkül*, II. P. 79-90. [Ganchimeg, G. (2024). Why did the Old Uyghur consonant z/ž became two different consonants in Mongolian. *Journal of Inner Mongolia University*, II. P. 79-90.]

Mören, Man . (1992). Mongyol kelen-ü qari yarultai üges-ün erel yarul-un tuqai. *Mongyol sudulul-un ögülel-ün tegübüri: Qayilar*. Hailar: Öbör mongyol-un soyul-un keblel-ün qoriy-a, P. 368-416. [Müren, M. (1992). Etymology of the loan words in Mongolian. *Proceedings of Mongolian Studies*. Hailar: Inner Mongolian Cultural press, P. 368-416.]

Li Baowen., Erkimtü. (2015). *Dotoyadu ba yadayadu tarni nom sonin qabtasuntur tamay-a čoqolbai*. Kökeqota: Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. [Li Baowen, Erkimtü (comp.), (2015). Reprinted Dhārṇī-Sūtra of the Tantric and Exoteric Buddhism. Hohhot: Inner Mongolian Peoples press.]

乌云毕力格 . (2013). 读1431年木刻版畏吾体蒙古文佛经序与跋——兼论古蒙古语语音向近代语音的过渡. *蒙古史研究*, 第十一辑. 第101-115页.[Oyunbilig (2013). Reading the preface and colophon of blockprint of the mongolian buddhist texts printed in 1431, About the transition of the phonology of the middle Mongolian to modern Mongolian. *Studia historica mongolica*, XI. P. 101-115.]

卡拉G. (2007). 东方学研究所圣彼得堡分所收藏哈喇浩特及西域出土中世纪蒙古文文献研究. 敖特根译. 北京: 民族出版社.[Kara, G. (2007). Mediaeval Mongolian Documents from Khara Khoto and Xiyu in the St. Petersburg Branch

of the Institute of Oriental Studies. Translated by Otqon. Beijing: The Ethnic Publishing House.]


吉田順一, チメドルジ . (2008). ハラホト出土モンゴル文書の研究. 東京: 雄山閣. [Yoshida Jun'ichi, Chimeddorji (2008). Study on the Mongolian documents found at Qaraqota. Tokyo: Yuzankaku press.]

嘎日迪 . (2004a). 敦煌莫高窟北区出土蒙古文文献标音释读 (一). 敦煌莫高窟北区石窟 (第二卷). 彭金章, 王建军编. 北京: 文物出版社, 第375-386页. [Garudi (2004a). Interpretation of Mongolian text found in the northern part of the Mogao Grottoes at Dunhuang (Part I). *Northern Grottoes of Mogaoku, Dunhuang* (Vol. II). Ed. Peng Jinzhang, Wang Jianjun. Beijing: Cultural Relics Press, P. 375-386.]

嘎日迪. (2004b). 敦煌莫高窟北区出土蒙古文和八思巴文文献标音释读 (二). 敦煌莫高窟北区石窟 (第三卷). 彭金章, 王建军编. 北京: 文物出版社, 第397-419页. [Garudi (2004a). Interpretation of Mongolian text found in the northern part of the Mogao Grottoes at Dunhuang (Part 2). *Northern Grottoes of Mogaoku, Dunhuang* (Vol. III). Ed. Peng Jinzhang, Wang Jianjun. Beijing: Cultural Relics Press, P. 397-419.]

敖特根. (2010). 敦煌莫高窟北区出土蒙古文文献研究. 北京: 民族出版社. [Otqon (2010). *Study on the Mongolian Documents from the Northern Area of Dunhuang's Mogao Caves*. Beijing: The Ethnic Publishing House.]

熊文彬, 郑堆主. (2011). 诸佛菩萨妙相名号经咒. 北京: 中国藏学出版社. [Xiong Wenbin, Zheng Dui. (2011). *Xylographs in Marvelous Images, Names, Sutras and Dharanis of the Buddhas and Bodhisattvas*. Beijing: China Tibetology Publishing]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.